



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/69

Пионер толгой

Өвсний үнэ хямдруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаваржилт хүндэрч, нойтон цас ихээр орсон нь мал төллөлтөд хүндээр нөлөөлж төл малын хорогдол үүсч малын зүй бус хорогдол нэмэгдэж байгаа тул малчдад дэмжлэг болгож сумын нөөцөд байгаа өвс тэжээлийг хавсралтад зааснаар хямдруулж малчдад олгосугай.

2.Өвс тэжээлийг хавсралтад дурдсан үнээр худалдан борлуулахыг нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай), нярав (П.Цэцэгдэмбэрэл) нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Э.Сүглэгмаад үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

